



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр

Утас: 89275858

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 106

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 14 дүгээр зүйлийн 13.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 13.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,090.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Дархан Уул аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3,002.0 мянган төгрөгийн зурагт, аяга таваг угаагч, 4,600.0 мянган төгрөгийн 3 хаалгатай шарах шүүгээг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2315 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 809,285.5 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 32.2 хувиар өссөн байна.

4528050132

### **Бусад асуудлын хэсэг**

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>174,717,013.72</b>	<b>109,883,799.38</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>79,788,348.36</b>	<b>14,530,367.02</b>
31211	Төрийн сангийн харилцах	79,788,348.36	14,530,367.02
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>94,928,665.36</b>	<b>95,353,432.36</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>414,600.00</b>	<b>605,250.00</b>
3513	Эм боох материал	414,600.00	605,250.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>94,514,065.36</b>	<b>94,748,182.36</b>
35410	Бичиг хэргийн материал	842,000.00	309,450.00
35420	Аж ахуйн материал	65,156,227.36	69,957,662.36
3545	Барилгын засварын материал	23,118,000.00	19,191,000.00
3546	Хүнсний материал	3,742,638.00	3,634,870.00
35470	Бусад хангамжийн материал	1,655,200.00	1,655,200.00
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>813,707,394.11</b>	<b>821,918,112.41</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>813,707,394.11</b>	<b>821,918,112.41</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>802,832,856.75</b>	<b>811,043,575.05</b>
39201	Барилга, байгууламж орон сууц	775,241,742.46	775,241,742.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,766,272.29)	(72,361,182.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,489,269.20	60,456,859.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,595,160.91)	(11,240,929.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,139,297.00	43,465,730.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,126,573.42)	(8,719,199.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,583,540.06	32,583,540.06
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,509,565.35)	(9,236,185.37)
39217	Ном	1,376,580.00	853,200.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>10,874,537.36</b>	<b>10,874,537.36</b>
39301	Программ хангамж	2,253,800.00	2,253,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,113,262.64)	(2,113,262.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,734,000.00	10,734,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>988,424,407.83</b>	<b>931,801,911.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>4,535,465.55</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,535,465.55
413	Өглөг		4,535,465.55
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		4,535,465.55
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>988,424,407.83</b>	<b>927,266,446.24</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	988,424,407.83	927,266,446.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,018,567.05	162,018,567.05
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	269,665,964.30	208,508,002.71
51210	Өмнөх үеийн үр дүн	269,665,964.30	269,665,964.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(61,157,961.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	556,739,876.48	556,739,876.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>988,424,407.83</b>	<b>931,801,911.79</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,070,635,860.00</b>	<b>1,136,663,130.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>148,393,360.00</b>	<b>46,289,130.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	148,393,360.00	46,289,130.00
<b>1200042</b>	<b>Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих</b>	5,000,000.00	-
<b>1200045</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,279,750.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	124,393,360.00	18,464,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	19,000,000.00	20,545,020.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>922,242,500.00</b>	<b>1,090,374,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	812,712,500.00	910,728,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>109,530,000.00</b>	<b>179,645,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	109,530,000.00	179,645,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>905,917,231.73</b>	<b>1,196,528,454.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>905,917,231.73</b>	<b>1,196,528,454.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>893,545,111.04</b>	<b>1,196,510,228.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>612,094,629.91</b>	<b>809,285,495.39</b>
210101	Үндсэн цалин	399,459,420.91	475,408,310.83
210102	Нэмэгдэл	186,216,357.00	283,608,341.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,420,531.00
210104	Урамшуулал	26,418,852.00	28,848,312.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,303,642.06</b>	<b>100,623,169.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,259,500.00	68,413,769.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,265,800.00	8,052,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,132,900.00	4,026,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,132,900.00	4,026,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,512,542.06	16,104,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>101,524,779.31</b>	<b>144,325,724.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,390,096.68	8,231,817.66
210302	Түлш, халаалт	81,471,468.62	117,145,262.26
210303	Цэвэр, бохир ус	13,663,214.01	18,948,644.63
210304	байрны түрээс	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,213,000.00</b>	<b>22,048,385.00</b>
210401	Бичиг хэрэг	717,000.00	4,555,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал		17,492,535.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,845,214.00</b>	<b>50,552,674.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,795.00	20,400.00
210502	Хоол, хүнс	50,721,419.00	50,532,274.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,008,620.00</b>	<b>42,314,950.00</b>
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-

210604	Урсгал засвар	4,008,620.00	42,314,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,450,000.00</b>	<b>1,720,000.00</b>
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,450,000.00	1,720,000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,105,225.76</b>	<b>25,639,830.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,431,235.00	7,349,076.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,268,300.00	1,800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,405,690.76	16,490,754.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,372,120.69</b>	<b>18,225.45</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,364,100.00</b>	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,364,100.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,020.69</b>	<b>18,225.45</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,020.69	18,225.45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,292,637.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,292,637.56
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>164,718,628.27</b>	<b>(61,157,961.59)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>164,718,628.27</b>	<b>(61,157,961.59)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>927,242,500.00</b>	<b>1,090,374,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,000,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,000,000.00</b>	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>922,242,500.00</b>	<b>1,090,374,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>812,712,500.00</b>	<b>910,728,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	812,712,500.00	910,728,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>109,530,000.00</b>	<b>179,645,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,530,000.00	179,645,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>891,658,516.97</b>	<b>1,155,381,981.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>891,658,516.97</b>	<b>1,155,381,981.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>879,286,396.28</b>	<b>1,155,363,755.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>612,094,629.91</b>	<b>805,230,799.34</b>
210101	Үндсэн цалин	399,459,420.91	471,353,614.78
210102	Нэмэгдэл	186,216,357.00	283,608,341.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,420,531.00
210104	Урамшуулал	26,418,852.00	28,848,312.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,303,642.06</b>	<b>100,142,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын	53,259,500.00	67,933,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын	6,265,800.00	8,052,300.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,132,900.00	4,026,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,132,900.00	4,026,200.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,512,542.06	16,104,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>101,524,779.31</b>	<b>144,325,724.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,390,096.15	8,231,817.66
210302	Түлш, халаалт	81,471,468.62	117,145,262.26
210303	Цэвэр, бохир ус	13,663,214.54	18,948,644.63
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,662,795.00</b>	<b>50,424,506.00</b>
210502	Хоол, хүнс	49,662,795.00	50,424,506.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>7,997,200.00</b>	<b>35,301,950.00</b>
210604	Урсгал засвар	7,997,200.00	35,301,950.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,100,000.00</b>	<b>1,720,000.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,100,000.00	1,720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,603,350.00</b>	<b>18,218,376.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,430,650.00	12,201,526.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,172,700.00	6,016,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,372,120.69</b>	<b>18,225.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,364,100.00</b>	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	12,364,100.00	-

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	.	.
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,020.69	18,225.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,020.69	18,225.45
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	35,583,983.03	(65,007,981.34)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	3,115,700.00	250,000.00
	Дотоод эх үүсвэрээр	3,115,700.00	250,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,729,700.00	
223001	Бусад хөрөнгө	386,000.00	250,000.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,115,700.00)	(250,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	32,468,283.03	(65,257,981.34)
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	79,788,348.36
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,468,283.03	14,530,367.02

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>162,018,567.05</b>	<b>556,739,876.48</b>	<b>269,665,964.30</b>	-	<b>988,424,407.83</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	162,018,567.05	556,739,876.48	269,665,964.30	-	<b>988,424,407.83</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			-		-
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>162,018,567.05</b>	<b>556,739,876.48</b>	<b>269,665,964.30</b>	-	<b>988,424,407.83</b>
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	162,018,567.05	556,739,876.48	269,665,964.30	-	<b>988,424,407.83</b>
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			(61,157,961.59)		<b>(61,157,961.59)</b>
D08	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>162,018,567.05</b>	<b>556,739,876.48</b>	<b>208,508,002.71</b>	-	<b>927,266,446.24</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,176,696,100.00</b>	<b>1,155,613,755.89</b>	<b>(21,082,344.11)</b>	<b>98.21</b>
21	Урсгал зардлын дүн	1,176,696,100.00	1,155,613,755.89	(21,082,344.11)	98.21
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>1,176,696,100.00</b>	<b>1,155,363,755.89</b>	<b>(21,332,344.11)</b>	<b>98.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>805,230,800.00</b>	<b>805,230,799.34</b>	<b>(0.66)</b>	<b>100.00</b>
210101	Үндсэн цалин	468,592,900.00	471,353,614.78	2,760,714.78	100.59
210102	Нэмэгдэл	313,045,400.00	283,608,341.56	(29,437,058.44)	90.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,420,531.00	21,420,531.00	
210104	Урамшуулал	23,592,500.00	28,848,312.00	5,255,812.00	122.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,142,400.00</b>	<b>100,142,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,933,000.00	67,933,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,052,300.00	8,052,300.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,026,200.00	4,026,200.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,026,200.00	4,026,200.00	-	100.00
210205	ЭМД-ын хураамж	16,104,700.00	16,104,700.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>155,766,800.00</b>	<b>144,325,724.55</b>	<b>(11,441,075.45)</b>	<b>92.65</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	8,810,400.00	8,231,817.66	(578,582.34)	93.43
210302	Түлш, халаалтын зардал	123,151,500.00	117,145,262.26	(6,006,237.74)	95.12
210303	Цэвэр бохир усны зардал	23,804,900.00	18,948,644.63	(4,856,255.37)	79.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>57,993,900.00</b>	<b>50,424,506.00</b>	<b>(7,569,394.00)</b>	<b>86.95</b>
210501	Эм	-	-	-	
210502	Хоол хүнс	57,993,900.00	50,424,506.00	(7,569,394.00)	86.95
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,319,300.00</b>	<b>35,301,950.00</b>	<b>(17,350.00)</b>	<b>99.95</b>
210604	Урсгал засвар	35,319,300.00	35,301,950.00	(17,350.00)	99.95
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>3,373,400.00</b>	<b>1,720,000.00</b>	<b>(1,653,400.00)</b>	<b>50.99</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,373,400.00	1,720,000.00	(1,653,400.00)	50.99
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,869,500.00</b>	<b>18,218,376.00</b>	<b>(651,124.00)</b>	<b>96.55</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,848,300.00	12,201,526.00	(646,774.00)	94.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,021,200.00	6,016,850.00	(4,350.00)	99.93

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>250,000.00</b>	250,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		250,000.00	250,000.00	
	Тоног төхөөрөмж			-	
	Бусад хөрөнгө		250,000.00	250,000.00	
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,176,696,100.00</b>	<b>1,090,355,774.55</b>	(86,340,325.45)	<b>92.66</b>
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
		985,610,000.00	910,709,874.55	(74,900,125.45)	<b>92.40</b>
131001	Нэмэлт санхүүжилтийн орлого	985,610,000.00	910,709,874.55	(74,900,125.45)	<b>92.40</b>
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	70,126,700.00	70,126,700.00	-	<b>100.00</b>
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
		<b>191,086,100.00</b>	<b>179,645,900.00</b>	(11,440,200.00)	<b>94.01</b>
132001	Орон нутгийн төсвөөс	191,086,100.00	179,645,900.00	(11,440,200.00)	<b>94.01</b>
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		79,788,348.36		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,530,367.02		
1	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
				-	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>				
		28.00	26.00	(2.00)	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	17.00	16.00	(1.00)	100.00
	Үйлчлэх ажилтан	10.00	9.00	(1.00)	100.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,925.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулав.

Үүнд:

- Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгагдаагүй хөрөнгийг бүртгэх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” 5.1.4. “үнэн зөв байх” заалт, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 4,303.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,703.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.2 Илрүүлэлт:** Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Отгонпүрэв сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх) буюу Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1.Илрүүлэлт:** Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч С.Отгонпүрэв нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**5.2.2.Илрүүлэлт:** Тайлант онд тус сургуулийн нягтлан бодогч Д.Отгончимэгт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул 1,559.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгаадаагүй хөрөнгийг бүртгэх	1	5,925.3	-	-	-	-	1	5,925.3	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,925.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>5,925.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Отгонпүрэв сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0								

Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч С.Отгонпүрэв нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,144.0			1	2,144.0						
Тайлант онд тус сургуулийн нягтлан бодогч Д.Отгончимэгт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул 1,559.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	1,559.0			1	1,559.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,303.0</b>	<b>1</b>	<b>600.0</b>	<b>2</b>	<b>3,703.0</b>	-	-	-	-	-	-

